

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 25/05

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, “Бодь Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.12.12 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнг үндэслэн татварын дараах цэвэр ашгаас 1,141,377,290 (нэг тэрбум нэг зуун дөчин нэгэн сая гурван зуун далан долоон мянга хоёр зуун ер) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 5 (тав) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг 2025 оны 04-р сарын 30-ны дотор ҮЦТХТ ХХК-аар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлсүгэй.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал А.Энхжаргалд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БИЛЭГТ